

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ  
САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР  
ТӨМӨР ЗАМЫН ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР :**

2026 оны 5 сарын байдлаар:

- Хууль-1
- Дүрэм, журам-5
- Стандарт-1
- Бусад эрх зүйн баримт бичиг /3/-т санал өгч ажилласан байна.

“Хууль тогтоомжийн хэрэгжилт хангах тухай” Улсын байцаагчийн 145 заалт бүхий 17 албан шаардлага хүргүүлсэн ба зөрчил арилгалт 77%-тай.

Үйл ажиллагааны 15 дүгнэлт, 2 зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлж ажилласан байна.

Төлөвлөгөөт 3, төлөвлөгөөт бус 19, гүйцэтгэлийн шалгалт 2 хийгдэж, биелэлт 81%-тай, зөвлөн туслах үйлчилгээ 2-ийг үзүүлсэн байна.

Төмөр замын салбарт мөрдөгдөж байгаа Төмөр замын зам, замын байгууламжтай холбоотой стандарт, дүрэм, журмыг сурталчлах хүрээнд 6 аж ахуйн нэгжийн 450 гаруй иргэнд 4 удаагийн сургалт зохион байгуулсан. Мөн хэвлэл мэдээллийн 2 сайтад төмөр замын чиглэлээрх холбогдох мэдээллийг өгч ажилласан.

Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээнд Төмөр, замын байгууламжийг байнгын ашиглалтад оруулах, зохион байгуулах, хяналт тавих ажлын хүрээнд:

Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны 03 дугаар сарын 05-ний өдрийн А/38 дугаартай, 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/94 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нь

- “Гобикорп сервисээ” ХХК-ийн 26/01
- “Шарын гол” ХК-ийн 26/02
- “Хялганат” ХХК-ийн 26/03
- “Тэс петролиум” ХХК-ийн 26/04
- “Силверспринг” ХХК-ийн 26/05
- “Шинэ эрин ойл” ХХК-ийн 26/06 дугаартай дүгнэлтээр салбар төмөр зам, төхөөрөмж байгууламжийг байнгын ашиглалтад оруулсан.

Аж ахуй нэгж, байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу техникийн нөхцөлийн дүгнэлтийн шаардлагыг хангасан:

- “Эрдэс стандарт” ХХК-ийн 26/01
- “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 26/02
- “Өгөөж гурил” ХХК-ийн 26/03
- “Амгалан зам” ХХК-ийн 26/04
- “Баз интернэшнл” ХХК-ийн 26/05
- “Сүмбэр алт люкс” ХХК-ийн 26/06
- “Петроген” ХХК-ийн 26/07
- “Силверспринг” ХХК-ийн 26/08
- “Стандарт энерги энд ойл” ХХК-ийн 26/09
- “Эн эл си” ХХК-ийн 26/10 дугаартай нийт 10 компанийн төмөр зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрлийг олгож
- “Цэцэнс холдинг” ХХК-ийн 24/31
- “Би и эс эл” ХХК-ийн 24/33
- “Контлайн” ХХК-ийн 25/02
- “Ресус альянс” ХХК-ийн 25/03

- “Оюут ухаа ложистик” ХХК-ийн 25/08 дугаартай нийт 5 компанийн төмөр зам, замын байгууламжийн барилгын ажлыг үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгох ажлыг зохион байгуулж ажилласан.

## **ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР:**

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төмөр замын газраас төмөр замын чиглэлээр хийсэн хяналт шалгалтын чиглэлээр:

- Улсын ерөнхий байцаагчийн баталсан 04/17 дугаартай удирдамжийн дагуу “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Ачааны вагон депогийн объект, засвар үйлчилгээ хийх үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах тухай Улсын байцаагчийн 04-00-03/014/08 дугаартай
- Улсын ерөнхий байцаагчийн баталсан 04/81 дугаартай удирдамжийн дагуу “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Замын-Үүд ложистикийн төвийн дохиолол холбооны байгууламж, түүнд засвар үйлчилгээ хийх үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах тухай Улсын байцаагчийн 04-00-03/012/45 дугаартай
- Улсын ерөнхий байцаагчийн баталсан 25/04-13-03/141/02 дугаартай удирдамжийн дагуу “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Замын 2 дугаар ангийн объект, засвар үйлчилгээ хийх үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах тухай Улсын байцаагчийн 04-13-03/141/04 дугаартай
- Улсын ерөнхий байцаагчийн баталсан 25/04-13-03/141/03 дугаартай удирдамжийн дагуу “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Дохиолол холбооны 2 дугаар ангийн объект, засвар үйлчилгээ хийх үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах тухай Улсын байцаагчийн 04-13-03/141/10 дугаартай
- Улсын ерөнхий байцаагчийн баталсан 25/04-13-03/141/08 дугаартай удирдамжийн дагуу “УБТЗ” ХНН-ийн Дохиолол холбооны 1 дүгээр ангийн объект, засвар үйлчилгээ хийх үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах тухай Улсын байцаагчийн 04-13-03/141/13 дугаартай
- Улсын ерөнхий байцаагчийн баталсан 25/04-13-03/006/21 дугаартай удирдамжийн дагуу “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Баянтүмэн тасагт хяналт шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах тухай Улсын байцаагчийн 04-13-03/009/12 дугаартай албан шаардлагуудыг хүргүүлж ажилласан.